



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/9/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.16

№

85

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.АНГИРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Шүүхийн тамгын газрын 1 хөтөлбөр 5 арга хэмжээний хүрээнд нийт 3,332.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 3,098.5 сая төгрөгийг зарцуулж, үйл ажиллагааны үр дүнгээр 89.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Жилийн эцсээр 142.4 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна

Аудитын гол асуудлууд

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 14 дүгээр тогтоолоор шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, шүүхийн захиргааны ажилтны албан тушаалын цалин хөлсийг тогтоох журам шинэчлэгдсэн баталсны дагуу цалин хөлсийг олгосон байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 40.0 хувиар буюу 724.6 сая төгрөгөөр өссөн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

6325050119

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31. /төгрөгөөр/
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	25,980,118.0	11,493,589.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	819,780,279.8	1,084,085,250.7
	Нийт хөрөнгийн дүн	845,760,397.8	1,095,578,839.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	7,163,891.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	845,760,397.8	1,088,414,948.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	845,760,397.8	1,095,578,839.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,656,788,045.7	3,650,073,784.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,597,340,643.9	3,405,324,898.7
	Үйл ажиллагааны үр дүн	59,447,401.7	244,748,886.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	2,094,335.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	59,447,401.7	242,654,551.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	786,312,996.1	845,760,397.8
	Тайлант оны үр дүн	59,447,401.7	242,654,551.0
	Эцсийн үлдэгдэл	845,760,397.8	1,088,414,948.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,596,201,122.0	3,316,227,550.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,526,469,222.0	3,288,146,550.2
	Үйл ажиллагааны ЦМГ	69,731,900.0	28,081,000.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(80,135,800.0)	(29,697,100.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(10,403,900.0)	(1,616,100.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,020,000.0	1,616,100.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,616,100.0	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	3,098,486,454.3
	Урсгал зардал	-	3,098,486,454.3
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	3,098,486,454.3
	Улсын төсвөөс санхүүжих	-	3,098,486,454.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Ахамдын сангийн үлдэгдлийн авлагаар тусгаагүй	1	16.1	1	16.1			1	16.1				
Дүн	1	16.1	1	16.1	0	0	1	16.1	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	-	0	-	0	-	0	-
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	0	-	0	-	0	-	0	-

-oOo-